



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 1/331

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай "Бат дайчин" ХХК /4073886/-ийн эзэмшлийн 4500 метр квадрат газраас 120 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Баасанхүүгийн Очирбат /пю90060735/-д шилжүүлж, амины орон сууцны зориулалтаар 77, гараашны зориулалтаар 24, хаягийг Бат Монгол 1 дүгээр гудамжны 120 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай "Бат дайчин" ХХК /4073886/-ийн эзэмшлийн 4500 метр квадрат газраас 98 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Баярхүүгийн Золбаяр /пя90121238/-д шилжүүлж, амины орон сууцны зориулалтаар 74, гараашны зориулалтаар 24, хаягийг Бат Монгол 2 дугаар гудамжны 224 тоот болгон 15 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ө.Долбадрал)-т даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01_{ah} 1677